

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ.....</b>	<b>3</b>
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22
Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/580  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН  
ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2020\0221SAG25.Docx

001590674

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.1. Оршил

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Бадрал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинэчлэн боловсруулах, зардлын дансны бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу хөтлөх, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 02-ноос 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж нар хариуцаж хэрэгжүүлэв.

Онцгой байдлын ерөнхий газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 9/170 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Онцгой байдлын ерөнхий газар нь эрхэм зорилгоо “Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Онцгой байдлын ерөнхий газар үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;
- Мэргэжлийн удирдлагаар хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг бодлого, хууль, журамд материаллаг шинж чанартай шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

Онцгой байдлын ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “EMERALD” программ хангамж ашигладаг байна.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 37,497,898.9 мянган төгрөгөөс тооцон 749,957.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 565,496.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,423,214.8 мянган төгрөгөөр буюу 18.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, биет хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	760,245.7	885.4	(759,360.3)
Урьдчилгаа	166,790.5	112,269.6	(54,520.9)
Бараа материал	4,752,128.8	5,150,135.9	398,007.1
Биет хөрөнгө	6,940,420.9	4,932,752.4	(2,007,668.5)
Биет бус хөрөнгө	320,428.1	320,755.9	327.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12,940,014.0</b>	<b>10,516,799.2</b>	<b>(2,423,214.8)</b>
Өр төлбөр	5,785,222.6	0	(5,785,222.6)
Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/	470,087.6	470,087.6	0
Хуримтлагдсан үр дүн	4,199,300.2	7,562,061.3	3,362,761.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,485,403.6	2,484,650.3	(753.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>12,940,014.0</b>	<b>10,516,799.2</b>	<b>(2,423,214.8)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд татан төвлөрүүлсэн Швейцарын хөгжлийн сангийн үлдэгдэл санхүүжилт 121,795.2 мянган төгрөг, гал түймрийн хандив 638,450.5 мянган төгрөгийг буцаан авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь оны эцэст худалдан авч бэлтгэсэн 598,900.0 мянган төгрөгийн тусгай зориулалттай материалыг харьяа байгууллагуудад шилжүүлээгүйгээс шалтгаалжээ.

Тайлант оны машин, тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал 2,009,804.6 мянган төгрөг нь үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад голлон нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд өглөг үүсгэсэн 4,975,355.8 мянган төгрөгийн тэтгэвэрт гарсан албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан нийт 24,056,274.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 23,676,101.7 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Гадаад төсөл, хөтөлбөр хандив тусламжаар орлогоор 425,703.3 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангаас 5,103,016.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 743,923.7 мянган төгрөг, нийт 6,272,643.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлжээ.

Үүнээс бараа, үйлчилгээний зардалд 6,232,017.2 мянган, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 33,000.0 мянган төгрөгийг зарцуулж 7,626.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,679,920.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,442,554.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 184,691.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 52,674.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Бүртгэл тайлагналтай холбоотой 2,442,554.9 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ХХОАТ-ын тайлангийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнг 89,709.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 320,198.9 мянган төгрөгийн өртөгтэй газар эзэмших 3 гэрчилгээнд нийт 34,949.6 мянган төгрөгөөр хасагдуулга тооцоолсон;
- Барилга, байгууламжийн элэгдлийн зардлыг 1,689,339.4 мянган төгрөгөөр илүү тооцоолсон;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны зардал болон үйл ажиллагааны бус орлогыг 628,556.4 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн.

Аудитаар 184,691.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тусгай зориулалтын тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ үзүүлэх 25 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 5,553,432.4 мянган төгрөгийн гэрээний үнийн дүнгээс чанарын баталгааны барьцаа 184,691.0 мянган төгрөгийг суутгаагүй олгосон нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, тайлагналт, хяналт тавих журам"-ын 4.18-д "Захиалагч нь барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт материалыг үндэслэн шилжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Тус агентлагийн санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг зурж төсвийг захиран зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д "дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна", 16.4.5-д "агентлагийн дарга тус агентлагийн төсвийн" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 52,674.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нарийвчлан шалгах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Онцгой байдлын ерөнхий газар “Шилэн дансны тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу 81 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

2019 оны завсрын аудитаар өгсөн 300.0 мянган төгрөгийн зөрчил арилгах төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй ба 18,400.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба хэрэгжилт 71.4 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө бүх ажил гүйлгээг авлага, өглөг, бараа материалын дансаар дамжуулан бүртгэсэн, бодлогын баримт бичигт 2016 оноос хойш шинээр нэмэгдсэн, өөрчлөгдсөн холбогдох хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, холбогдох хууль, тогтоомж, стандарттай нийцэхгүй байх, санхүүгийн тайлан, мэдээ буруу илэрхийлэгдэх.

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, стандартад нийцүүлэн шинэчилж өөрчлөх, данс бүртгэлийг холбогдох журмын дагуу үнэн зөв хөтлөх, зөрчлийг давтан гарахгүй байх.

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3.2 Орлогын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын зарцуулалттай хамааралгүй 45,053.4 мянган төгрөгийн зардал гаргасан байгаа нь Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журам"-ын 1.3.2-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Хууль, журам мөрдөгдөхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах, зориулалт бус зардал гаргахгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3.3 Зардлын данстай холбоотой асуудал**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

Автомашинны гаалийн татварт төлсөн 7,620.9 мянган төгрөгөөр тухайн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж бүртгээгүй байгаа нь НББОУС 16-ийн 16-д "Үндсэн хөрөнгийн өртөг дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: а. Гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татварын дүнг оруулсан худалдааны хөнгөлөлт, буцаалтыг хассаны дараах худалдан авалтын үнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

#### **3.3.2 Эрсдэл:**

Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сул, үнэн зөв батламж мэдэгдэл хангагдаагүй байх.

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгийн дансны үнийг холбогдох стандарт, журмын дагуу үнэн зөв тооцоолох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3.4 Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### **3.4.1 Илрүүлэлт:**

Өмнөх онууд болон тайлант онд Онцгой байдлын ерөнхий газрын аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.4.2 Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байх.

#### **3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн төвлөрүүлэн захирагч Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллах, үр дүнг тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,679,165,042.11</u></b>	<b><u>5,263,290,922.34</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>760,245,716.16</b>	<b>885,392.00</b>
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	885,392.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	760,245,716.16	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>166,790,533.28</b>	<b>112,269,616.72</b>
34600	Урьдчилж гарсан зардал	166,790,533.28	112,269,616.72
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,752,128,792.67</b>	<b>5,150,135,913.62</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,161,310,809.01</b>	<b>1,909,201,351.97</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,161,310,809.01	1,908,643,191.97
35130	Эм боох материал	-	558,160.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3,590,817,983.66</b>	<b>3,240,934,561.65</b>
35410	Бичиг хэргийн материал	269,411,278.62	149,941,533.40
35420	Аж ахуйн материал	100,101,434.01	134,313,260.45
35430	Сэлбэг хэрэгсэл	5,820,000.00	135,922,875.04
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	-	250,000.00
35460	Хүнсний материал	39,233,985.00	36,649,785.00
35470	Бусад хангамжийн материал	3,176,251,286.03	2,783,857,107.76
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,260,849,009.09</u></b>	<b><u>5,253,508,269.90</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7,260,849,009.09</b>	<b>5,253,508,269.90</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,940,420,922.44</b>	<b>4,932,752,405.51</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,544,920,635.79	3,542,964,144.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,764,702.04)	(165,750,601.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж	10,539,435,288.65	10,701,766,561.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,325,546,305.04)	(9,335,350,910.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	547,248,179.43	559,688,436.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(328,886,717.42)	(371,564,951.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,557,495.55	12,880,091.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,542,952.48)	(11,880,364.64)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	-	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>320,428,086.65</b>	<b>320,755,864.39</b>
39301	Програм хангамж	13,551,820.80	13,951,820.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,322,654.15)	(13,394,876.41)
39303	Бусад биет бус хөрөнгө	320,198,920.00	320,198,920.00
39304	Хасагдуулга	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>12,940,014,051.20</u></b>	<b><u>10,516,799,192.24</u></b>

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>5,785,222,606.16</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>5,785,222,606.16</u></b>	<b>-</b>
<b>413</b>	Өглөг	5,785,222,606.16	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
4136	Бусад өглөг	5,785,222,606.16	-
41361	Байгууллагад төлөх өглөг	809,866,767.16	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,975,355,839.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,154,791,445.04</u></b>	<b><u>10,516,799,192.24</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>7,154,791,445.04</u></b>	<b><u>10,516,799,192.24</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,087,565.96	470,087,565.96
51101	Өмч: - төрийн	470,087,565.96	470,087,565.96
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,199,300,225.21</b>	<b>7,562,061,363.61</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	4,199,300,225.21	4,200,053,616.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,362,007,747.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,485,403,653.87	2,484,650,262.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>12,940,014,051.20</u></b>	<b><u>10,516,799,192.24</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>32,615,882,620.06</b>	<b>31,636,817,405.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>978,236,903.27</b>	<b>2,102,161,854.61</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	978,236,903.27	2,102,161,854.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	978,236,903.27	2,101,326,310.61
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,218,493.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	974,018,410.27	2,101,326,310.61
120009	Бусад орлого		835,544.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>31,637,645,716.79</b>	<b>29,534,655,550.44</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	19,890,335,400.00	23,892,835,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,890,335,400.00	23,892,835,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,747,310,316.79	5,641,819,950.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	251,893,026.79	425,703,270.79
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	11,439,900,826.00	5,103,016,866.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,516,464.00	113,099,812.85
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>37,303,636,616.17</b>	<b>28,274,809,657.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>37,303,636,616.17</b>	<b>28,274,809,657.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>24,152,467,607.80</b>	<b>25,874,082,698.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,743,323,100.00	1,884,967,470.23
210101	Үндсэн цалин	1,015,312,300.00	1,083,354,598.23
210102	Нэмэгдэл	645,900,500.00	721,650,972.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,110,300.00	79,961,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,460,803.07	40,416,035.80
210201	Тэтгэврийн даатгал	24,839,021.79	27,482,904.34
210202	Тэтгэмжийн даатгал	9,600.00	3,233,282.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,586,626.29
210204	Ажилгүйдлийн даатгал	-	646,656.57
210205	Эрүүл мэндийн даатгал	33,612,181.28	6,466,565.73
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	199,072,520.94	201,512,742.16
210301	Гэрэл, цахилгаан	117,729,009.04	84,867,973.44
210302	Түлш, халаалт	57,224,282.81	36,853,336.69
210303	Цэвэр, бохир ус	4,708,898.09	13,385,416.46
210304	Байрны түрээс	19,410,331.00	66,406,015.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	432,341,602.97	475,549,327.61
210401	Бичиг хэрэг	120,570,983.00	246,241,532.22
210402	Тээвэр, шатахуун	7,962,409.00	5,826,800.00



210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,918,334.53	44,198,389.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,655,000.00	1,840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	233,603,575.00	177,442,605.56
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	25,631,301.44	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,227,255,509.80</b>	<b>3,407,694,153.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	972,166.00	3,946,450.00
210502	Хоол, хүнс	28,510,041.30	2,439,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,197,773,302.50	3,401,308,503.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,658,663,852.37</b>	<b>3,330,181,540.20</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	176,848,545.00	1,517,435,396.54
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	970,375,899.37	177,822,919.70
210604	Урсгал засвар	511,439,408.00	1,634,923,223.96
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,997,730.00</b>	<b>12,554,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	11,997,730.00	12,554,000.00
